



ХОВД АЙМАГ  
МОНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 23

Сэнхэр

Г Төсөл сонгон шалгаруулах зөвлөл  
байгуулах тухай Г

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтооолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3.3 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Б.Батболд

-Сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: А.Эрдэнэттуул

-ЗДТГ-ын жижиг, дунд үйлдвэрлэл  
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Ц.Ганболд

-Сумын Засаг даргын орлогч

К.Цэнд-Аюуш

-Териин банкны эдийн засагч

Э.Баярмаа

-ХААН банкны эдийн засагч

Б.Чинбат

-Баялаг бүтээгчдийн холбоо

С.Бат-Оргил

-Баялаг бүтээгчдийн холбоо

Ш.Сүхбаатар

-Сэнхэр багийн иргэн

Л.Энхцоож

-Борт багийн иргэн

Д.Даваасүрэн

-Алаг багийн иргэн

Э.Эрдэнэбат

-Хаг багийн иргэн

2. Тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчлийн 2013 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 18 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг иргэдийн оролцоотой, ил тод, нээлттэй сонгон шалгаруулж, хэрэгжилт, үр дүнг хагас, бүтэн жилээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Зөвлөлийн бүрэлдэхүүн /Б.Батболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Я.ОЧИР

D; Togtool;2017.04.24



ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 24

Сэнхэр

Хяналтын зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтооюор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын Здугаар зүйлийн 3.3.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Б.Батзаяа	-Сумын ИТХ-ын Тэргүүлэгч
Гишүүд:	Ш.Тогооч	-ЗДТГ-ын Терийн сангийн төлөөлөгч
	У.Оюунбилэг	-Терийн банкны салбарын эрхлэгч
	О.Алтантуяа	-ХААН банкны салбарын эрхлэгч
	Д.Маамбаа	-Баялаг бүтээгчдийн холбоо
	Б.Чинзориг	-Сэнхэр багийн иргэн
	Т.Буянхишиг	-Борт багийн иргэн
	Э.Энхсад	-Алаг багийн иргэн
	Б.Батзаяа	-Хаг багийн иргэн

2. Тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтанд хяналт тавьж, зээлийн хэрэгжилт, үр дүнг хагас, бүтэн жилээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Зөвлөлийн бүрэлдэхүүн /Б.Батзаяа/-д даалгасугай.



D; Togtool;2017.04.24



ХОВД АЙМАГ  
МОНХХАЙРХАН СҮМҮН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20/7 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 25

Сэнхэр

Г Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн сумын Засаг даргаас өргөн мэдүүлсэн "журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдсан "сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-д дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

а/ Журмын 1.5.3 дахь заалтанд "зээл олгох дээд хэмжээ 5,0 сая төгрөг гэснийг 15,0 сая төгрөг" гэж өөрчилсүгэй.

б/ Журмын 3.2.8-д "Үйл ажиллагаагаа эхлэн 30 хувийн санхүүжилтээ өөрөө хийсэн байх" гэсэн заалтыг нэмсүгэй.





ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 26

Сэнхэр

Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах сумын салбар  
нийгэмлэгийг шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын даргын оруулсан саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга:  
Нарийн бичгийн дарга:  
Гишүүд:

- Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
- Сумын ЗДТГ-ын эрхзүйн ажилтан
- Сумын ХХАА-ын улсын байцаагч
- Сумын БОХ-ын улсын байцаагч
- Сумын Нийгмийн ажилтан
- Сургуулийн Нийгмийн ажилтан
- Сумын ЗДТГ-ын газрын даамал
- Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
- Сумын Олон нийтийн цагдаа
- Сэнхэр багийн бага эмч
- Сэнхэр багийн Засаг дарга

2. Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах талаар гаргасан хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах талаар үр дунтэй ажил зохион байгуулж, хийсэн ажлын мэдээллийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээ жил бүрийн 11 дүгээр сард багтаан танилцуулж ажиллахыг Нийгэмлэгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР



ХОВД АЙМАГ  
МОНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛӨГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 27

Сэнхэр

Г Сумын 90 жилийн ой тэмдэглэх товыг  
өөрчлөн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 22 дугаар зүйлийн 22.1.4 дахь заалтыг үндэслэн сумын Засаг дарга Б.Батболдын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сум үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойг 2017 оны 7 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд тэмдэглэхээр товыг өөрчлөн тогтоосугай.

2. Ой тэмдэглэх товыг нийт иргэдэд зарлаж, баяр наадмын хөтөлбөр гарган батлуулж, 5 дугаар сард багтаан урилга хэвлүүлж айл өрх, иргэд, зочид төлөөлөгчдөд хүргүүлэхийг Ой зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн сумын Засаг дарга /Б.Батболд/-даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.





ХОВД АЙМАГ  
МОНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 28-адар


Дугаар 28

Сэнхэр

Г Төрийн дээд шагналд тодорхойлох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол одон, медалиар шагнах журам”-ыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

2. Мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, улс эх орон, баг сумынхаа хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулсныг өндөрөөр үнэлж тус сумын Борт багийн иргэн Сэнгээ овогтой Сүхээ, Дуламжав овогтой Сүрэнжав нарыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнуулахаар тодорхойлж уламжилсугай.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР



ХОВД АЙМАГ  
МОНХХАЙРХАН СҮМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТӨГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 29

Сэнхэр

Г Төрийн дээд шагналд тодорхойлох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол одон, медалиар шагнах журам"-ыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТӨГТООХ нь:

1. Мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, улс эх орон, баг сумынхаа хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулсныг өндөрөөр үнэлж тус сумын Борт багийн иргэн Цэрэндорж овогтой Олдохыг Монгол Улсын Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавьяаны улаан түгийн одон"-гоор шагнуулахаар тодорхойлж уламжилсугай.





ХОВД АЙМАГ  
МОНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 50

Сэнхэр

Г Эрүүл мэндийн салбар зөвлөлийг  
шинэчлэн байгуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 425 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын Засаг дарга Б.Батболдын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТӨГТООХ нь:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг сумын хэмжээнд зохицуулах үүрэг бүхий сумын Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Б.Батболд	-Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Энхбулган	-Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
Гишүүд:	Я.Сувд-эрдэнэ Б.Түвшинзориг О.Бишгарам	-Нийгмийн эрүүл мэндийн ажилтан -12 жилийн сургуулийн захирал -“Хатан-Сэнхэр” эмэгтэйчүүдийн ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн
Г.Мөнхтуул	-Сумын Нийгмийн бодлогын ажилтан	
О Алтансувд	-Халамж үйлчилгээний мэргэжилтэн	
Б.Бадамцэцэг	-ЗДТГ-ын нягтлан бодогч	
Г.Түвшинтөр	-Цагдаагийн төлөөлөгч	
М.Огтонбаатар	-Байгаль хамгаалагч	
С.Мөнхтулга	-Сэнхэр багийн Засаг дарга	

2. Салбар зөвлөлийн ажиллах журмыг мөрдлөг болгон эрүүл мэндийн талаар баримтлах бодлого чиглэлийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллаж зөвлөлийн ажлын тайланг жил бурийн 10 дугаар сард сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг зөвлөлийн дарга /Б.Батболд/-д даалгасугай.



Я.ОЧИР

D. Togtool:2017.05.22



ХОВД АЙМАГ  
МОНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 31

Сэнхэр

Г Нийтийн халуун усны үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "г", 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Нийтийн халуун усны үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг 2017 оны 6 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2017-оны 5 дугаар сарын 22-ны  
өдрийн 31 дүгээр тогтоолын хавсралт



НИЙТИЙН ХАЛУУН УСНЫ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ

/мянган төгрөг/

Д/Д	Төрөл	Үнэ
1	Насанд хүрэгчид /2 хүн/	4000
2	Насанд хүрэгчид /1 хүн/	2500
3	Хүүхэд /8-12-р анги/	2000
4	Хүүхэд /1-7-р анги/	1500
5	Цэцэрлэгийн насны хүүхэд	1000

-о О о-



ХОВД АЙМАГ  
МОНХХАЙРХАН СҮМҮН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРКҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 32

Сэнхэр

Г Хуралдаан товлон зарлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1, 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэркүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4 дүгээр хуралдааныг 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн "мягмар" гаргат сумын төвд хуралдуулахаар товлон зарласугай.

Хоёр.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1/ Сумын төвийн мал бүхий өрхөд тавигдах шаардлага, түүнийг зохицуулах журамд өөрчлөлт оруулах тухай илтгэл.

2/Хөх нуурын амралтын газарт амрагч, жуулчдаас авах хураамжийн хэмжээг тогтоох тухай илтгэл

3/ Сумын 90 жилийн ойн хандивын бүрдүүлэлт, зарцуулалт, бүтээлч ажил, ойн бэлтгэл ажлын явцын тухай илтгэл

4/ Сумын 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай илтгэл

Гурав. Хуралдаанаас гарах шийдвэрийн төслүүдийг боловсруулан бэлэн болгож, хуралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулалт сайтай хуралдуулахыг нарийн бичгийн дарга /О.Бишгарам/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Я.ОЧИР